



БӨӨНИЙ ХУДАЛДАА ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022.04.12

Дугаар № БХ202203

Улаанбаатар хот

2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай

Бөөний Худалдаа ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 04 сарын 12-ны өдрийн ээлжит хуралдааны шийдвэр, Компанийн дүрмийн 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн, Компанийн тухай хуулийн 59.4, 62 дугаар зүйлийг удирдлага болгон ТОГТООХ нь:

НЭГ. “Бөөний худалдаа” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийт хувьцаа эзэмшигчдийг зайнаас хуралдаа оролцох боломжийг харнгах зорилгоор 2022 оны 5 сарын 20-ны өдрийн 16:00 цагт, “Бөөний худалдаа” ХК-ийн Баянгол дүүрэг, 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Компанийн байранд ZOOM программ ашиглан цахим хэлбэрээр зохион байгуулахаар товлосугай.

ХОЁР. Хурлаар хэлэлцэх асуудал болон хуралдааны дэгийг хавсралт №1-д зааснаар баталсугай.

ГУРАВ. Хурлын даргаар ТУЗ-ийн дарга Б.Дөлбадрахыг томилсугай.

ДӨРӨВ. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2022 оны 05 сарын 01-ний өдрөөр тасалбар болгож, олон нийтэд 2022 оны 04 сарын 15-ны өдөр мэдээлсүгэй.

ТАВ. Хурал зохион байгуулах, болон тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

С.Наранцэцэг- хүний нөөц

У.Нямдорж- менежер

И.Мөнхжаргал-захиргааны ажилтан

ЗУРГАА. Хуралдаантай холбогдон гарах зардлыг Компаниас гаргахыг зөвшөөрсүгэй.

ДОЛОО. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан хурлаар хэлэлцэх асуудлын талаар мэдээлэл өгөх, хавсралт №2-д заасан баримттай танилцуулах ажлыг 2022 оны 05 сарын 16-18-ны өдрүүдэд хувьцаа эзэмшигч нарт хүндрэлгүйгээр цахим хэлбэрээр зохион байгуулахыг комисст даалгасугай.

НАЙМ. Хувьцаа эзэмшигчдийн хуралдааны санал хураах хуудасны загварыг Хорооны 2020 оны 880 тоот тогтоолоор баталсан журмын хүрээнд тогтоолын хавсралт №2-оор баталсугай.

ЕС. Эчнээ саналын хуудас хүлээн авах өдрийг 2022 оны 05 сарын 16-ны өдөр эхлүүлж, 2022 оны 05 сарын 19-ний өдрийн 18 цагаар тасалбар болгосугай.

АРАВ. Хурлын зарыг Уг тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид мэдэгдэхийг ТУЗНБД-д даалгасугай.

АРВАН ХОЁР. Ээлжит хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах болсонтой холбогдуулан программын аюулгүй байдлыг ханган төлбөрт үйлчилгээнд хамрагдан, хувьцаа эзэмшигч нарт программын заавар зааварчилгааг өгч, хуралдаа саадгүй оролцох нөхцөлөөр ханган ажиллахыг Комисст үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.ДӨЛБАДРАХ

ТТА4519-н. 2075776

2021 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын тов болон хурлын дэг

№	Хэлэлцэх асуудал	Хариуцан танилцуулах, гүйцэтгэх хүн	Шийдвэрийн төсөл	Хугацаа
1	Хурлын ирцийг бүртгэх Ирцийг танилцуулах	ТУЗНБД ZOOM апп нээж хувьцаа эзэмшигч нарт ID болон PASS кодыг өгөх		16:00-16:30
2	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон дэгийг танилцуулах	Хурлын дарга Б.Дөлбадрах		16:30-16:35
3	Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт	Аудитын хороо	001	13:35-14:35
4	БХ2202 тоот ногдол ашиг хуваарилахгүй байх тухай тогтоолыг танилцуулах тайлбар хийх	Аудитын хороо		
5	ТУЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай	ТУЗ-ийн дарга Б.Дөлбадрах	002	
6	ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай	Нэр дэвшүүлэх хороо	003	
7	Санал хураалт			17:35-17:50
8	Тооллогын комиссын тогтоол танилцуулах		007	17:50-18:00
9	Хурлыг хаах			18:00-18:10

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН 2022 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
САНАЛ АВАХ ХУУДАС**

1. Хувьцаа эзэмшигчийн овог _____
2. Хувьцаа эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр _____
3. Хувьцаа эзэмшигчийн нэр _____
4. Итгэмжлэлээр оролцож байгаа бол төлөөлөгчийн мэдээлэл _____
5. Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар _____
6. Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар _____
7. Санал өгөх хувьцааны тоо _____
8. Бүртгэсэн / брокер, диллер/ компанийн нэр _____
9. Брокерын овог, нэр _____

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт/ 001 тоот тогтоолын төсөл/			
2	Ногдол ашгийн тухай тогтоолыг танилцуулах тайлбар хийх			
3	ТУЗ-ийн 2020 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай / 002 тоот тогтоолын төсөл/			
4	ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах, чөлөөлөх сонгох /003 тоот тогтоолын төсөл/			
5	Компанийн хэлбэрийг өөрчлөх төсөл эхлүүлэх зөвшөөрөл олгох тухай 004 тоот тогтоолын төсөл			
6	Компанийн дүрэм шинэчлэн батлах тухай 005 тоот тогтоолын төсөл			
7	Бусад / ТУЗ-ийн гишүүдийн зүгээс шийдвэрлүүлэхээр оруулж буй санал/ 006 тогтоол			

Кумулятив аргаар санал өгөх 003 тоот тогтоол. ТУЗ-ийн гишүүд

ТУЗ-ийн гишүүдийн тоо	Нийт саналын эрхийн тоо	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчид						Хараат бус гишүүнд нэр дэвшигчид		

Хувьцаа эзэмшигчийн санал _____

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ _____ / _____ /

(гарын үсэг)

(гарын үсгийн тайлал)

Өдөр тутмын хэвлэлд өгөх зарын төсөл

БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Бөөний Худалдаа ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 16:00 цагт Бөөний худалдаа ХК-ийн оффисын байранд ZOOM программ ашиглан цахим хэлбэрээр зохион байгуулагдана.

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Бөөний худалдаа ХК-ийн байрны 101 тоот

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр 2022.05.01

Хурлаар хэлэлцэх асуудлууд

- Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт
- Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай
- ТУЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай
- ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах, чөлөөлөх, томилох тухай
- Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай төсөл эхлүүлэх тухай
- Бусад асуудал / ТУЗ-ийн гишүүдээс шийдвэрлүүлэхээр оруулж буй асуудал/

Хурлын материал болон, шийдвэрийн төсөл холбогдох бусад баримттай 2022 орны 05 сарын 16-18-ны өдрүүдэд 95111286 дугаартай холбогдон хуралд оролцох эрхээ баталгаажуулан холбогдох мэдээллийг цахим хэлбэрээр И-мэйлээр хүлээн авч танилцах боломжтой

Холбоо барих

Зохион байгуулах комиссын дарга: 95111286



БӨӨНИЙ ХУДАЛДАА ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022.01.06

Дугаар № БХ2202

Улаанбаатар хот

НОГДОЛ АШГИЙН ТУХАЙ

Бөөний Худалдаа ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 01 сарын 06-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 46.1; 46.5 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Бөөний худалдаа ХК-ийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтээр Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл хангаагүй байх тул 2022 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтсугай.

ХОЁР. Тогтоолыг Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл 46.6 дахь заалтын дагуу 2022 оны хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, тайлагнахыг Аудитын хороонд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ДӨЛБАДРАХ